

## ГУДАМЖНЫ ГЭРЭЛ ЗУРАГ МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРГИЙН ГОЛ ТӨРӨЛ БОЛОХ НЬ

Д.Золбоо

**Abstract:** Монголд гэрэл зураг хөгжсөнөөс хойш гудамжны гэрэл зураг зэрэгцэн хөгжсөн байна. Өнөө үед гэрэл зургийн төрлүүдээс гудамжны гэрэл зураг хүчтэй хөгжиж байгаа билээ. Уг судалгаагаараа бид дэлхийн болон Монголын гудамжны гэрэл зургийн хөгжил хийгээд гудамжны гэрэл зургийг тодорхойлсон байдлыг авч үзсэн. Ингэснээр гудамжны гэрэл зургийн хөгжлийг тодорхой харуулж, монголын гудамжны гэрэл зургийг судалгааны эргэлтэд оруулж, гудамжны гэрэл зургийн үнэлэмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Since the development of photography in Mongolia, street photography has developed simultaneously. Nowadays, street photography is emerging strongly among the types of photography. In this study, we considered the development of world and Mongolian street photography and the definition of street photography. In this way, it is crucial to clearly show the growth of street photography, bring Mongolian street photography into the research cycle, and increase the value of street photography.

**Түлхүүр үг:** гэрэл зураг, гэрэл зургийн хөгжил, гудамжны гэрэл зураг, монголын гудамжны гэрэл зураг

**Key words:** photography, growth of street photography, mongolian street photography, street photography

Монголчууд XIX зууны сүүлийн жилүүдэд монгол орноор судалгаа шинжилгээ хийж байсан Герман, Орос, Хятад, Франц, Америк зэрэг олон орны монгол судлаач, Дорно дахиныг судлагч эрдэмтдээс судалгаа шинжилгээний гэрэл зургийн ид шидийн гэмээр гайхамшигтай танилцсан түүхтэй. Тухайлбал, Францын аялагч, нийтлэгч, гэрэл зурагчин Степан Пассений *Халх эхнэр*, Английн дэслэгч Жеральд Чарльз Бинстийдийн *Охид, хүүхнүүд хүрдний өмнө*, цаашлаад “Америкийн Р.Эндрьюс, Ч.Эндрьюс, Р.Шакейлфорд, Оросын Ю.Козлов, Н.Перих, А.Бурдуков, Ефремов, Германы Х.Хаслунд зэрэг томоохон эрдэмтэн, судлаач, аялагчдыг нэрлэж болно. 1921 онд Үндэсний ардчилсан хувьсгалын дараа бүртгэл, тооллого хийхэд хүрээнд хятад [гэрэл] зурагчны газар цөөнгүй тоологджээ.

1935 онд Монгол улсад анх гэрэл зургийн алба үүссэнээс хойш монголд гэрэл зургийн салбар олон төрөл, чиглэл болон хөгжсөөр өдийг хүрчээ. Энэ хугацаанд гэрэл зурагчин, судлаачид төрөн гарч, гэрэл зургийн тухай ном, сурах бичиг, судалгааны ажлууд хэвлэгдэн нийтлэгдсээр ирсэн. Тухайлбал, гэрэл зураг хэрхэн авах, гэрэл сүүдэр хэрхэн тохируулах зэрэг гэрэл зургийг техник хэрэгсэл болох талаас 1977 онд Х.Дамдин, П.Дашхүү нар “Гэрэл зураг”, 2008 онд М.Лхагвасүрэн, Л.Элбэгзаяа нар “Гэрэл зураг: Гэрлээр бичих урлагийн сурах бичиг” зэрэг ном хэвлүүлсэн. Гэрэл зурагчдын намтар түүхийн талаас 2015 онд Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооноос “Монголын гэрэл зурагчид 1935-2015”, 2015 онд В.Баттулга “Ертөнцийг гэрлээр бичих урлаг” хэмээх ном тус тус бичсэн. Харин фото сэтгүүл зүйн төрлөөр 1987 онд М.Лхагвасүрэн “Фото нийтлэлийн төрөл зүйл, өнөөгийн

шаардлага”, 2008 онд Л.Норовсүрэн “Монгол сэтгүүлзүйн түүхэн тойм”, мөн онд “Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл”, 2012 онд “Фото сэтгүүл зүй” (Их дээд сургуулийн сурах бичиг) зэргийг тус тус хэвлүүлж байв. 2016 онд П.Маш-Эрдэнэ “Монголын гэрэл зургийн сэтгүүл зүйн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” нэртэй бакалаврын судалгааны ажил бичсэн байна. Эдгээрээс гадна гэрэл зураг яаж авах зөвлөгөө бүхий номууд ч хэвлэгдэж байв. Үүнд 1986 онд фото сэтгүүлч М.Лхагвасүрэнгийн хэвлүүлсэн “100 асуултын хариу” номыг дурдаж болно. Харин гэрэл зурагчин, Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж буй Ц.Батбаатар “Монголын гэрэл зургийн түүх”, Н. Баянмөнх “Фото нийтлэл, түүний төрөл зүйлийн асуудал” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан байна. Хэдийгээр гэрэл зургийн түүх, фото сэтгүүл зүйн төрлөөр ном, бүтээл хэвлэгдэж байгаа ч гудамжны гэрэл зургийн төрлөөр нарийвчлан авсан судалсан судалгаа одоохондоо алга байна.

### Гудамжны гэрэл зургийн товч түүх

XIX зууны эхэн үед “Дагерын арга”<sup>1</sup>-аар гэрэл зураг боловсруулах болсноор дэлхийн өнцөг булан бүрд гэрэл зураг авч, боловсруулах болжээ. Тэдгээр аялагч-гэрэл зурагчид<sup>2</sup>-ын бүтээл урьд хожид хэний ч хараагүй сонин хот, улсуудыг буулгах зорилготой байснаас бус өнөөгийн бидний ойлгож, томъёолдог хот, гудамж талбайн гэрэл зураг биш байлаа. XIX зууны сүүлээр овор хэмжээ багатай, ороомог хальс<sup>3</sup>-тай, хямд үнэтэй камер олноор үйлдвэрлэх боломжтой болсноор хот, гудамж талбайгаар явж зураг авах хүний тоо эрс нэмэгдсэн билээ.

Гэрэл зургийн түүхч, куратор Колин Вестербек, гэрэл зурагчин Жоел Мейерович нар 1994 онд бичсэн *Bystander: A History of Street Photography* (1994) номдоо, “гудамжинд өрнөх өдөр тутмын амьдралын кандидат<sup>4</sup> зураг” хэмээн тодорхойлжээ. Сюсан Сонтаг *On Photography* (1975) номдоо “Гэрэл зурагчид бол туршиж, мөшгөж, төв газрын гудамжаар хэсүүчлэгч камер гэдэг зэмсэг барин ганцаар алхагч, эрс тэс таашаалаар дүүрэн ландшафт гэдгийг мэддэг, дэндүү сониуч тэнүүлчин юм” хэмээн тодорхойлсон нь хот, гудамж талбайн гэрэл зурагчдад илүү хамаатай, оновчтой тодорхойлолт болсон байна. Мөн тэрээр уг номдоо Францын яруу найрагч Шарль Бодлерын *flâneur* буюу хэсүүчлэгч, сэлгүүцэгч гэх нэршлээс Волтер Беньяминийн гэрэл зурагчинтай холбосон сэлгүүцэгчийн тухай хотын орчин үеийн гудамжны амьдралыг ажиглан, сэлгүүцэн явагч хэмээх ойлголтыг “Харж таашаахдаа сурамгай, бусдын зовлонг ойлгодог сэлгүүцэгч энэ ертөнцийг ‘зураг шиг сайхан’ гэж хардаг” хэмээн тодорхойлжээ. Сэлгүүцэгч нь хөл хөдөлгөөн, дуу шуугианаар дүүрэн, хурдтай хувиран өөрчлөгдөж буй орчин үеийн их хотын амьдрал дахь агшин зуурын үзэгдлээр тоглож чаддаг. Тэрээр идэвхгүй үйлчлүүлэгч, жирийн ажиглагч, эсхүл зугаацан алхагч байхын оронд орон хоттойгоо уран бүтээлчийн дүрээр нүүр тулдаг байна. Сэлгүүцэгчээс их хотыг цуврал зураг болон хувиргахад тодорхой сургуулилалт тодорхой мэдрэмж, туршлага бүхий хараа шаарддаг<sup>5</sup>.

1890 онд Лондоны гудамж, далайн эрэг дээр авсан Пол Мартин Сан Францискогийн Хятад хороололд авсан Арнолд Гент (тэд хоёулаа камераа нууж, гэрэл зураг авсан) нарын ил тод байдлыг харуулсан, нууцаар түргэн авсан зургууд, Эжен Ажтегийн Парис хотын харуй бүрий болсон үеийн навсгар гудамж, хуучирч, муудсан худалдааны газрууд, Брассайн ‘Парисын шөнө’ (*Paris de nuit*, 1933) номд дүрсэлсэн янаглал, ганцаардал, Вижигийн ‘Нүцгэн хот’ (*Naked*

<sup>1</sup> Хамгийн анхны өргөн хэрэглэгдэж эхэлсэн гэрэл зураг авах арга. Зэс хавтанг өнгөлж, мөнгөөр бүрээд гэрэлт мэдрэмтгий йодид түрхэнэ. Уг хавтанг гэрэл нэвтрүүлдэггүй саванд хийж зөөн камерт суулгах ба дурангаар туссан дүрс уг хавтан дээр буух юм. Ингээд мөнгөн усны уураар боловсруулсны дараа өмнө нь ил харагдахгүй байсан дүрс хавтан дээр тодорч гарч ирнэ.

<sup>2</sup> Гэрэл зураг үүсэн хөгжиж байх үед гэрэл зурагчид болон гэрэл зураг сонирхогчид дэлхийн олон хот, тосгоноор аялан явж гэрэл зураг авдаг байв.

<sup>3</sup> Гэрэл мэдрэх шинж чанартай галогенид мөнгөний түрхлэг бүхий 0,12-0,17 мм-ийн зузаантай тунгалаг ялтас

<sup>4</sup> Гэрэл зургийн субъектийг зураг авхуулахад зориулж зохиомлоор дүр байдал гаргуулахгүйгээр шууд авсан гэрэл зураг.

<sup>5</sup> Warren, Lynne. *Encyclopedia of 20<sup>th</sup> Century Photography Volume 1*. 2005. New York: Routledge.

City, 1945) дээрх эмгэнэлт жүжиг адил хотын зургууд бол Валтер Беньямины сэлгүүцэгчийн олон янзын жишээ юм<sup>6</sup>. Ингэхээр хот, гудамж талбайн гэрэл зурагчид бол гудамжаар алхаж, энгийн амьдралыг ажиглан дурангаа тийш чиглүүлэгч бөгөөд тэдний дуранд өртсөн хотын амьдрал, нийгмийг шүүмжлэх, хотоо магтан дуулах, эсхүл зүгээр л гэрэл зурагчин хувийн мэдрэмжээ илэрхийлэх зорилгоор гэрэл зураг авдаг.

Гудамжны гэрэл зургийн түүх нь технологийн дэвшил, шинэ ололттой салшгүй холбоотой. Тодруулбал, “Желатин<sup>7</sup> мөнгөний хэвлэл”<sup>8</sup> хэрэглэснээр гэрэлтүүлгийн үед камераа гурван хөлт тулгуур<sup>9</sup> дээр хөдөлгөөнгүй байлгах шаардлагагүй болсон. 1870-аад оны сүүлээр желатин мөнгөний хэвлэлийн түрхцэд гарсан дэвшлийн ачаар гэрэлтүүлгийн хугацааг секундын 1/25 буюу түүнээс ч бага болгон бууруулсан нь гэрэл зурагчид камераа гартаа бариад чөлөөтэй хөдөлж, гэрэл зураг авах боломжтой болжээ” (Баттулга нар, 2015: 15). Хожим 1888 онд Америкийн хуурай хавтан буюу желатин хавтан<sup>10</sup> үйлдвэрлэгч Жорж Истман анх Кодак камер<sup>11</sup> худалдаанд гаргасан. “Кодак камер нь авч явахад авсаархан байгаад зогсохгүй, хальс боловсруулах<sup>12</sup> үйл явцыг компани хариуцсанаар камер эзэмшигчдийн тоо өсөхөд нөлөөлж гэрэл зураг боловсруулах үйлдвэрлэлийг эхлүүлсэн юм<sup>13</sup>. Ийнхүү гэрэл зураг сонирхогчдын тоо эрс өсөж, хүн бүр гэрэл зурагчин болох боломж бүрдсэнээр Валтер Беньямины сэлгүүцэгчдийн тоо нэмэгджээ “1924 онд Германд фото сэтгүүлзүйн хувьсал гаргасан хоёр камер бүтээгдсэний нэг нь Оскар Барнаж хэмээх эрдэмтний зохион бүтээсэн 35мм-ийн Лейка гэх камер байсан бөгөөд урьд өмнө бүтээгдэж байсан овор багатай гэгдэж байсан камеруудыг бодвол илүү дэвшилттэй байв” (Баттулга нар, 2015: 15).

Сэлгүүцэгчтэй хамт баримтат гэрэл зурагчин, гэрэл зургийн сэтгүүлчдийн тоо ч нэмэгдсэн байна. Тиймээс гудамжны гэрэл зураг нь баримтат гэрэл зураг, фото сэтгүүл зүйтэй маш ойр төдийгүй хоорондоо хөрвөх чадвартай. Үүний учир эдгээрийг нэг төрөл ангилалд багтаах тохиолдол ч байдаг. Тухайлбал, Роберт Франкын *The American* (1958) тавиад оны Америкчуудыг буулгасан гэрэл зургууд нь нэг талаар гудамжны гэрэл зургийн төрөлд багтдаг ч нөгөө талаар баримтат гэрэл зураг, гэрэл зурагчин Б.Инжинаашийн 2008 оны 7-р сарын 2-ны өглөөний дүр зураг нэг талаар гудамжны гэрэл зураг ч өмнөх өдрийн үйл явдлын ул мөрийг авснаараа баримтат гэрэл зураг болж байна. Гэрэл зургийн онол, түүхээр мэргэшсэн профессор Стив Эдвардс ‘Гудамжны гэрэл зураг’ эсхүл ‘баримтат гэрэл зургийн зохиолч’ гэдэг нь ихэвчлэн урлаг-гэрэл зурагтай нэг бүлэг болдог<sup>14</sup> хэмээн гудамжны гэрэл зураг урлагийн бүтээл болох талаас нь тодорхойлж, баримтат гэрэл зураг болон фото сэтгүүл зүйн бүтээлээс зааглан ялгаж өгчээ. Баримтат гэрэл зурагчин, фото сэтгүүл зүйч нь нийгэмд үйлчлэх үүрэгтэй оролцдог бол хот, гудамж, талбайн гэрэл зурагчин нийгмийн үйлчлэгч болон үйлчлүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг. Үйлчлүүлэгчийн үүрэгтэй оролцож байх үед тэдний бүтээл олон нийтийн эрх ашгийг хөндсөн, эсхүл уг цаг үеийн онцлогийг харуулсан байх албагүй байдаг. Тэд нийгэмд үйлчлэгчийн үүргээр оролцох үед тэдний бүтээлд шүүмж, анхааруулга нь ихэвчлэн далд хэлбэртэй байдаг. Мөн гэрэл зургийн бусад төрлөөс ялгагдах гол онцлог нь гудамжны гэрэл зурагчдын дуранд хүмүүс ямар нэг поз буюу байрлал авч, баг зүүж амжилгүй, байгаагаараа буудагт оршино.

<sup>6</sup> Sontag, Susan. *On Photography*. 1977. New York: Penguin.

<sup>7</sup> Амьтны гаралтай түүхий эдийг усанд чанаж хийсэн тунгалаг бодис. Желатиныг хальсан дээр дүрс үүсгэдэг гэрэлд мэдрэмтгий талстуудыг уусгах орчин болгон ашигладаг.

<sup>8</sup> Желатинд уусгасан мөнгө галидийн нэгдлээр бүрсэн цаасыг хэрэглэдэг 1882 онд нэвтрүүлсэн стандарт хар цагаан хэвлэлийн арга.

<sup>9</sup> Удаан барилттай зураг авах үед камераа хөдөлгөхгүй байх, эсвэл хөдөлгөөнтэй биесийг дүрслэх үед хэрэглэдэг. Гурван хөлт, нэг хөлт тулгуур гэж байдаг.

<sup>10</sup> Желатин түрхсэн хавтан.

<sup>11</sup> Олон нийт болон сонирхогчийн хэрэгцээнд зориулан гаргасан анхны камер.

<sup>12</sup> Гэрэлд мэдрэмтгий хальс дээр үл харагдах зургийг химийн аргаар бодит, харж болох зураг болгон өөрчлөх.

<sup>13</sup> Rosenblum, Naomi. *A World History of Photography*. [1981]:2005. New York: Abbeville Press.

<sup>14</sup> Edwards, Steven. *Photography: A Very Short Introduction*. 2006. Oxford: Oxford University Press.

Монголд хот, гудамж, талбайн гэрэл зургийн төрөл Гэрэл зургийн алба байгуулагдсанаас хойш одоог хүртэл тасралтгүй хөгжиж байна. Монголын гэрэл зургийн түүхийг нийгмийн дэвшил болон гэрэл зургийн хэрэгсэл, технологийн өөрчлөлтийг харгалзан үзэж таван үед хуваав. Өнөө үед Монголд өсөн нэмэгдэж буй гудамжны гэх тодотголтой гэрэл зурагчдын бүтээлийн үнэлэмж, уран бүтээлчдийн нэр хүнд, эдгээрийн судалгаа өсөн нэмэгдэнэ гэж үзэж байна. Бид нийгмийн байдал, техник технологийн хөгжлийг харгалзан үзэн багцалж, монголын гэрэл зургийн хөгжлийн түүхэн цаг хугацаагаар тав хуваасан. Энэ нь гудамжны гэрэл зургийн төрөл монгол оронд баримтат, болон фото сэтгүүл зүйн төрөлтэй мөр зэрэгцэн хөгжиж ирснийг олж харах боломжийг бидэнд олгох юм.

**1. Улсын гэрэл зургийн албанаас Соёлын яамны харьяа Улсын гэрэл зургийн газар, Нийтийн аж ахуйн үйлчилгээний гэрэл зургийн газар болж өргөжсөн үе буюу 1935-1957 он:** Ардын сайд нарын Зөвлөлийн 1935 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар “Монголд кино, гэрэл зургийн алба байгуулах тухай” асуудлыг тусгайлан авч хэлэлцжээ. Сайд нарын Зөвлөлийн 32-р хуралдааны тогтоолын 1-р зүйлд, “Тус улсын үндэсний байдлыг үзүүлэн гаргаж байх кино, зургийн үйлдвэрийг аль болох сурталчилгаатайгаар үүсгэн байгуулж, цаашид тус улсын кино зургийн хорооноос кино гэрэл зургийг үйлдвэрлэх эл хоёр зүйлийн ажлыг хослуулан гүйцэтгэх газар болговоос зохино” (Норовсүрэн нар, 2012: 53) хэмээн заажээ. 1937 оны орчмоос гэрэл зургийг сонин, хэвлэлд ашиглах болсон байна. “1937 онд Залуучуудын соёлын ордонд гэрэл зургийн үзэсгэлэн байгуулж үзүүлэхэд хотынхон ихэд сонирхож байв” хэмээн тус газрын анхны дарга Д.Гончигийн яриа баримт болон үлджээ.

Гэрэл зургийн алба нь албан байгууллагуудын захиалгаар үйлчилж, гэрэл зургийг ард түмний амьдралд нэвтрүүлж, шинжлэх ухааны ололтыг сурталчлах нь хувьсгалжуулагч үр нөлөөтэй арга хэлбэрийн нэг гэж үзэж, гэрэл зургийн албын байр суурийг бэхжүүлэн бататгах ажлыг дэс дараатайгаар явуулсаар 1939 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн МАХН-ын Төв хорооны хуралдаанаар “Улаанбаатар хот ба зарим аймгийн төвд гэрэл зургийн газрыг байгуулж, фото зургийн эргэлтийг хангахын тулд 8 дугаар сараас наана таваас зургаан аймагт зураг авах газар байгуулж дуусгасан байхыг Хүрээлэнгийн захиргаанд үүрэг болгосугай” хэмээн Уран сайхны хүрээлэнд үүрэг болгосон тогтоол гаргажээ. Мөн тогтоолд Улаанбаатар хотод шинэ, үлгэр жишээ бүхий фото зургийн газар байгуулах, Шинжлэх ухааны Хүрээлэнгийн зургийн газар, Кино Зургийн газруудын хүчийг хавсарган нэгтгэх, олон нийтэд үйлчлэх гэрэл зургийн яс чанарыг сайжруулж, үнийг хямдруулах зэрэг олон чухал заалт оржээ. Тогтоолд зааж, үүрэг болгосны дагуу сайн дурын гэрэл зурагчдыг бүртгэн авч, гэрэл зураг авах, камертай ажиллаж сурах ур чадвар мэдлэгийг хөгжүүлэх зорилготой бүлгэм байгуулах, гэрэл зураг хэрхэн авах тухай зааж зургах багш томилох, ажиллуулах, гэрэл зурагтай холбоотой ажлыг улс төрийн хийгээд соёл хүмүүжлийн ажлын төв болсон төвүүдийн клуб, улаан булангуудад харьяат болгон явуулах, цаашлаад сайн дурын гэрэл зурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж сурталчлах зэрэг ажлыг дас дараатай зохион байгуулж байжээ (Норовсүрэн нар, 2012: 54). “1940 онд гэрэл зурагчны нэг сарын курсийг нээн ажиллуулж, төгсөгчдийг бүх аймагт илгээж” (Баттулга нар, 2015: 60) байжээ.

Гэрэл зургийн алба бий болж, гэрэл зургийг олон түмэнд сурталчлах болсон нь сайн дураар гэрэл зураг авдаг, сонирхогчдыг бий болгоход ихээхэн нөлөөлжээ. Сайн дураар гэрэл зураг авах, сонирхох гэдэг нь европын гэрэл зургийн түүхэнд гудамжны гэрэл зурагчид бий болоход модерн үед гарч ирсэн Бодлерийн томъёолсон сэлгүүцэгч бий болох үндэс энэ үед тавигджээ. Гудамжны гэрэл зурагчид энэ үеэс буюу монголын гэрэл зургийн салбар үүсэж хөгжсөн үеэс төрөн гарах эхлэл нь тавигдсан байна. Тухайн үеийн гудамжны гэрэл зурагчдын сэдвийн хүрээ улс төрийн үзэл суртлаас хамаарч хязгаарлагдмал байсан нь дамжиггүй. Үүнээс гадна гэрэл зургийн камерын хүрэлцээ ч сэдэв болон бусад боломж нөөцийг хязгаарлагдмал болгож байсан. “Төвийн гэрэл зургийн газар нь “Лейка”, ЗХУ-д үйлдвэрлэсэн “Фэд” маркын



нарийн хальсны, 9х12 см-ийн хэмжээний (шилээр авдаг) “Фотокор”, 18х24 см-ийн хэмжээний (мөн шилээр авдаг) “Апломат” зэрэг цөөн хэдэн аппараттай байсан бөгөөд нийслэл хотноо бүтээгдэхүүнээ борлуулдаг дөрвөн мухлагтай” (Баттулга нар, 2015: 60) байсан байна.

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1957 онд Төвийн гэрэл зургийн газрыг задлах тогтоол гаргажээ. Ингэхдээ хоёр хэсэгт хуваасан байна: гэрэл зургийн гадаад, дотоод сурталчилгааг дагнан хийж, түүхэн үйл явдлын баримтыг үлдээж байх зорилготой БНМАУ-ын Соёлын Яамны харьяа Улсын гэрэл зургийн газар болон улс орны хөгжлийн хэрэгцээ шаардлагаас уламжлан хүн ардад өдөр тутам үйлчлэх зориулалттай Нийтийн аж ахуйн үйлчилгээний гэрэл зургийн газар (Норовсүрэн нар, 2012: 55). Ийнхүү гэрэл зураг авдаг үйлчилгээний газрууд нээгдсэн. Гэрэл зургийн үйлчилгээний тухай талбайн гэрэл зурагчин Ц.Хэнц “Тэр үед (1956 он) Өндөр хоршоо (одоогийн Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей), түүний урд Ард кино театр гээд том барилгууд байлаа. Өндөр хоршооны яг урд зах байрын газар, тэндээс нааш гудамжийг Төмөрчний гудамж гэдэг байв. Түүгээр явж байхад нарийхан даавуу шиг юм өлгөчихсөн жижиг пүүтк шиг юмнуудтай тааралдана. Тэдгээрийн нэг рүү нь ортол нэг хар юм барьчихсан хүн байлаа. Намайг үүгээр яадаг юм гэж асуутал “Зураг авдаг юм” гэв. “Зураг авна” гэж яадаг юм гээд би тэнд зургаа авхуулчихсан”<sup>15</sup> хэмээн дурсав.

Гэрэл зурагчдын бүтээлүүд дээр ажиглалт хийн 1935-1979 оны гудамжны гэрэл зурагчид бий болоход, энэ төрлийн гэрэл зургийг монгол оронд дэлгэрүүлэхэд нөлөөлсөн гэрэл зурагчин нь Цэнд-Аюушийн Дагдандорж юм. Тэрээр Монголын анхны фото сэтгүүлчдийн нэг бөгөөд 1939 онд дагалдан зурагчнаар нэгэн хувийн гэрэл зургийн газар ажиллаж байжээ. Зөвлөлтийн мэргэжилтэн Е.И.Колониноос анх гэрэл зургийн боловсрол олж авсан. Дагдандорж нь “1950 оноос “Туяа” сэтгүүлд фото сурвалжлагч, 1952 оноос “Үнэн” сонинд фото сурвалжлагч, тасгийн эрхлэгч зэрэг ажлыг хорь гаруй жил хийгээд 1964 онд тэтгэвэртээ гарсан байна” (Баттулга нар, 2015: 66). Хожим гэрэл зургийн багш болж хойч үеэ бэлтгэхэд хүчин зүтгэсэн байна. “...Санамсаргүй явтал чинь сайхан тохиол учирна гэдгийг бодож яв!” гэж шавь нартаа сургаж байснаас нь үзвэл Францын гэрэл зурагчин Анри Картьер-Брессоны “шийдвэрлэх мөч” хэмээх ухагдахуунтай тун дөхөж, эндээс тэр үеийн гэрэл зурагчид гудамжны гэрэл зураг авдаг байжээ гэдэг таамаглал дэвшүүлж болохоор байна. Мөн гэрэл зурагчин Л.Санжмятавын “1955 онд би 10-р ангид ороод ангийнхаа Түвшинцэнгэл гэдэг хүүхдээс Зоркий гэдэг камерыг нь 450 төгрөгөөр авсан. Тэгээд Баруун Хүрэннээс Зүүн хүрээнд байдаг зураг авдаг газар очсон”<sup>16</sup> гэх ярианаас тухайн үед нийтэд гэрэл зургийн үйлчилгээ явуулж байсныг мэдэж болох бөгөөд гэрэл зургийг ард иргэдэд таниулах, гэрэл зурагчин бэлтгэн гаргах ажил ид өрнөж байжээ.

**2. Соёлын яамны харьяа Улсын гэрэл зургийн газар, Мэдээлэл, радио, телевизийн улсын хорооны /МРТУХ/ гэрэл зургийн ерөнхий редакц хоёрыг нэгтгэж МРТУХ-ны харьяа Улсын гэрэл зургийн газар болгон өргөтгөсөн буюу 1957-1979 он:** Гэрэл зургийн газрыг радио телевизийн улсын хорооны гэрэл зургийн ерөнхий редакцтай нэгтгэсэн нь фото сэтгүүлчид төрөн гарахад гол үүдийг нээжээ. Эдгээр жилүүдэд “Намын үнэн”, “Үндэсний эрх”, “Ажилчны зам”, “Улаан од” зэрэг сонинуудаас гадна аймгуудад тогтмол хэвлэлийн газрууд ар араасаа байгуулагдаж байсан юм. Жишээ нь, 1942 онд Баян-Өлгий аймагт “Жана өмир” сонин, 1945 онд Дорноговь аймгийн тогтмол хэвлэл “Ялалт” сонин анхны дугаараа гарган 1960-80 онд хамгийн олон хувь хэвлэгдэж байжээ. 1964 онд Дархан хотын “Найрамдлын Дархан” сонин хэвлэгдэн гарч байжээ. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн ихэнх нь Улаанбаатар хотод хэвлэгдэж байсан. Тиймээс ч орон нутгийн мэдээ мэдээллийн зургуудыг авах фото сэтгүүлчид олон байлаа. Энэ үед монголын алдартай фото сэтгүүлчид төрсөн нь

<sup>15</sup> Талбайн гэрэл зурагчин Ц. Хэнцтэй 2017 оны 09-р сарын 20-нд 25-р телевизийн байрны нэгдүгээр давхарт ярилцав. Улаанбаатар хот.

<sup>16</sup> Гэрэл зурагчин Л. Санжмятав, Сүхбат нартай 2018 оны 4-р сарын 6-нд Туушин зочид буудлын 5-р давхрын 514 тоотод байрладаг Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны байранд ярилцав. Улаанбаатар хот.

М.Лхагвасүрэн, Б.Улятайхүү, Ц.Нина нар билээ. Мөн хот, хөдөөгийн өөрийн авсан гэрэл зургийг өгүүлэлтэй хамт нийтлэл маягаар сонин хэвлэлүүдэд илгээдэг идэвхтэн сэтгүүлчид олон байжээ. Талбайн гэрэл зурагчдын эхэн үеийн төлөөлөгч Б.Нямжав 1989 онд талбайн гэрэл зурагчин болохоосоо өмнө “Хөдөлмөр”, “Намын үнэн” гэх мэт сонинуудын идэвхтэн сурвалжлагчаар ажиллаж байснаа ярьсан юм. Харин энэ үеийн хот, гудамж, талбайн гэрэл зурагчин бол Ловуу овогтой Санжмятав билээ.

Тэрээр 1956 оноос гэрэл зураг авч эхэлсэн бөгөөд 1974 онд Берлин, Софи, Прага хотод гарсан социалист орнуудын гэрэл зургийн агентлагуудын хамтарсан үзэсгэлэнд “Монгол бүсгүй”, “Улаанбаатар” зэрэг бүтээлээр, 1983 онд “Энх тайван найрамдал” сэдэвт “Фото-83” хамтарсан үзэсгэлэнд оролцсон ба 2012 онд “Хотын хүний зураг”, 2018 онд “Хот, хотынхон” нэртэй гэрэл зургийн бие даасан үзэсгэлэнгээ дэлгэсэн. 2012 онд Монголд сэтгүүлзүйн 100 жилийн ойн гэрэл зургийн хамтарсан үзэсгэлэнд мөн оролцжээ. “ХГТГЗ гэдэг бол хотын хөгжлийг харуулж байдаг гэрэл зургийн нэг том төрөл. Энэ нь их хотын амьдрал, хөгжил цэцэглэлтийг харуулж байдгаараа онцлогтой. Миний гэрэл зургуудаас гудамжны хөдөлгөөнтэй гэрэл зургууд л миний хотыг хардаг өнцөг, үзэл санаа бүгд багтдаг. Би түүгээр л үзэл санаагаа илэрхийлж, өөрийгөө илчилж байдаг”<sup>17</sup> хэмээсэн юм. Энэ үед фото сэтгүүлзүйн төрлөөр гэрэл зураг авдаг уран бүтээлчид олноор төрсөн. Улс орны хөгжил цэцэглэл, уриа лоозонг харуулах буюу төр засгийн үйл ажиллагааг ард түмэнд ухуулах зорилготой байсан учраас бүтээлд нь хатуу шаардлага тавьдаг байжээ.

**3. Мэдээлэл, Радио, Телевизийн Улсын Хорооны харьяа Улсын Гэрэл Зургийн Газрыг МОНЦАМЭ агентлагт шилжүүлсэн үе буюу 1979-1990 он:** 1979 онд Соёлын Яамны Улсын Гэрэл Зургийн Газар, Мэдээлэл, Радио, Телевизийн Улсын Хорооны /МРТУХ гэж товчилно/ гэрэл зургийн ерөнхий редакц хоёрыг нэгтгэх шийдвэрийг дээд газар гаргажээ. Эдгээрийг нэгтгээд МРТУХ-ны харьяа гэрэл зургийн газар болгон өргөтгөжээ. Уг газрын зорилго нь гэрэл зургийг гадаадад болон дотооддоо сурталчлан таниулах байв. Зорилгынхоо хүрээнд ЗХУ, БНАГУ зэрэг оронд мэргэжлийн фото сэтгүүлчид бэлтгэгдэж, дотоодын сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт фото сэтгүүлзүйн хичээлийг оруулан заах болсон нь гэрэл зургийн сэтгүүлчдийн эгнээг өргөтгөж ур чадварыг ахиулахад чухал түлхэц болжээ (Баттулга нар, 2015: 63). Энэ үеэс эхлэн монголд гэрэл зураг сонирхогчдын тоо өсөж, тэд хувиараа камер хэрэгсэлтэй болсноор олон гэрэл зурагчин ХГТГЗ авах болжээ.

Энэ үед фото сэтгүүлзүйн төрлөөр ажилладаг гэрэл зурагчид суралцан төрсөн. Тэднийг бэлтгэгдэн гарахад ахмад гэрэл зурагчид гол үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэдний нэг нь Сандуйжавын Туяа юм. Тэрээр 1967 оноос гэрэл зураг авч эхэлсэн, 1978 онд БНАГУ-д Номын урлаг ба Графикийн дээд сургуулийг төгссөн. 1978-1992 онд Соёлын яамны харьяа Улсын гэрэл зургийн газарт гэрэл зурагчин, Мэдээлэл радио телевизийн улсын хорооны харьяа Улсын гэрэл зургийн газарт гэрэл зургийн сурвалжлагч, мэдээний редактор, 1982-1986 онд Дүрслэх урлагийн дунд сургуульд Гэрэл зургийн ангийн багш, 1992-2005 онд хувийн хэвшилд, 2005-2009 онд Монголын урлагийн зөвлөл, Хүүхдийг ивээх сангийн “Хүүхэд ба Дуран” төслийн багш, 2010 оноос “Сэтгүүлч” коллеж СУИС-ийн харьяа Радио телевизийн дээд сургуульд гэрэл зургийн багшаар ажиллаж”<sup>18</sup> байжээ.

Мөн Сүхбаатарын талбайгаар овоглосон гэрэл зурагчид бий болсон нь энэ үеийн дурдах ёстой онцгой үйл явдлын нэг юм. 1987 онд гэрэл зурагчид талбай дээр гэрэл зураг авч эхэлжээ. Ахмад гэрэл зурагчин Ц.Хэнз, “1990 оноос өмнө талбай дээр зураг үнэтэй авахыг зөвшөөрдөггүй байв. Цагдаа, сэргийлэх чанга хүн бараг оруулахгүй шахуу. Эхлээд бид нар айгаад гадуур нь хэсэг зогсож, талбайг тойрон явдаг байлаа. 1989 онд, яг хувьсгал эхэлж

<sup>17</sup> Гэрэл зурагчин Л. Санжмятав, Сүхбат нартай 2018 оны 4-р сарын 6-нд Туушин зочид буудлын 5-р давхрын 514 тоотод байрладаг Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны байранд ярилцав. Улаанбаатар хот.

<sup>18</sup> Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо. 2015. *Монголын гэрэл зурагчид: Press 1935-2015*. Улаанбаатар. 122 тал.

байхад, Элдэв-Очир кино театрын үүдний давхарт, урд, хойно гэсэн хоёр бие засах өрөөний урд хэсгийн бие засах өрөөг чөлөөлүүлээд тэнд хамаг юмаа тавьж үүдэнд буюу дотор нэг зурагчин, гадаа нэг зурагчинтай ажлаа эхлүүлсэн”<sup>19</sup> хэмээн тухайн үеийн нөхцөл байдлын тухай дурсан ярьсан юм. Тэрээр талбайн гэрэл зурагчин болохоосоо өмнө “Залуучуудын Үнэн”, “Үнэн”, “Хөдөлмөр”, “Улаанбаатарын мэдээ” зэрэг сонинуудад зургуудаа өгдөг фото сэтгүүлч байжээ.

**4. Ардчилсан нийгэмд шилжсэн, интернэтийн сүлжээнд холбогдсон үе буюу 1990-2000 он:** “Улс орон зах зээлийн харилцаанд шилжин нийгмийн байдал хэсэг зуур тогтворгүй, тодорхой бус болсон цаг үе гэрэл зургийн салбарт ч мөн нөлөөгөө үзүүлсэн билээ. МОНЦАМЭ агентлагийн харьяанд улсын гэрэл зургийн газрыг шилжүүлсэн санхүү эдийн засаг зэрэг хүчин зүйлээс болж үйл ажиллагаа нь зогссон байна” (Норовсүрэн нар, 2012: 55). Энэ үед нийгэмд гарсан өөрчлөлтөөс дурдвал, гэрэл зурагчдын эх хэрэглэгдэхүүн болох гэрэл зургийн камерт нэгэн том өөрчлөлт гарсан нь 1991 онд “Кодак” компани хамгийн анхны тоон системийн гэрэл зургийн камер амжилттай зохион бүтээж, дижитал гэрэл зургийн мэргэжил буй болсныг дэлхий дахинд” (Норовсүрэн нар, 2012: 141) тунхагласан явдал юм. “...1992 онд “Кодак”, “Филип” компаниуд хоршиж гэрэл зураг авахад хэрэглэх гэрэлт диск (Photo CD)-ийн системийг судлан гаргаж, хальс дээрх зургийг тоон системийн аргаар компьютерт юүлэн оруулж буулгах болжээ. Ингэснээр гэрэл зургийг компьютероор шийдвэрлэх, зураг хадгалах, дамжуулах зэрэг гэрэл зургагчдын дур сонирхолтой ажил үйлс бий болсон юм” (Норовсүрэн нар, 2012: 141). Дижитал камерыг уламжлалт камераас онцлох гол ялгаа нь хальс хэрэглэдэггүйд оршино.

Мөн энэ үед бий болсон томоохон өөрчлөлт нь интернэтийн үүсэл байлаа. Мэдээллийн Харилцаа ББХК (бүрэн бус хариуцлагатай компани) нь 1994 онд Монголд анх удаа Интернэтийн үйлчилгээ явуулж эхэлсэн нь Датаком компанийн эхлэл ба Монгол улс Интернэтэд өдөрт хоёр удаа холбогдож электрон шуудангийн дамжуулалт хийдэг байжээ. 1995 оны 12 сараас газрын станц суурилуулснаар Интернэтэд онлайнаар холбогдох боломж бий болсон. Улмаар интернэтийн төрөл бүрийн үйлчилгээ хэрэглээг Монголд бий болох чухал үүрэг гүйцэтгэжээ. “1996 оны 1-р сарын 17-нд Монгол улсад Интернэт нэвтэрснийг албан ёсоор зарлажээ” (Болд-Эрдэнэ нар, 2009: 86). “1996 онд Интернэт хэрэглэгчдийн тоо Монголд 500 гаруйхан байв... Хэвлэлийн хүрээлэнгийнхэн өнгөрсөн гуравдугаар сарын (2009 оны 3 сар) хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгааг хийх явцдаа нийслэлийн интернэт хэрэглэгчдийг судалж, кибер зах зээлийн бодит өөрчлөлтийг танджээ. Судалгаагаар нийслэлчүүдийн 73.2 хувь нь интернэт хэрэглэдэг болох нь батлагдсан байна” (Болд-Эрдэнэ нар, 2009: 87).

1990 он гараад “МОНЦАМЭ агентлагийн гэрэл зургийн салбарын архивд байсан гэрэл зургууд Улсын төв архивд шилжсэн” (Норовсүрэн нар, 2012: 57). Үүнээс хойш монголын гэрэл зургийн салбарт тохиосон томоохон үйл явдал нь гэрэл зургийн сэтгүүлч Ц.Батзориг, С.Цацралт, Л.Ганзориг нарын санаачилгаар 1996 оны 6 дугаар сарын 25-нд “ТАММА” агентлаг, 1998 оны 12 дугаар сард гэрэл зургийн сэтгүүлч Р.Энхбатын санаачилгаар “Эдмон” компанийн дэргэд “Фотомон” ХХК байгуулагдсан явдал юм. Энэ үеийн гэрэл зурагчид улс оронд болж буй цаг үеийн мэдээ мэдээллийг сурвалжлахаас гадна хот, гудамж, талбайн гэрэл зургуудыг авч байлаа. Хэдийгээр ардчилсан нийгэмд шилжсэн ч гэсэн 1935 онд байсан шиг гэрэл зургийг төр засгийн ухуулга хэлбэрээр ашиглахгүй ч нийгэмд тохиолдож байсан асуудлуудыг төр баригчдад хүргэх зуучийн үүргээр ашиглаж байлаа. Үүний хамгийн том жишээ бол гэрэл зурагчин Ц.Батзоригийн 1993 онд Баянхонгор аймгийн Гурван булаг суманд болсон зуднаар авсан зураг билээ. “Энэ гэрэл зургийн ачаар улс даяараа хөдөлж, зудаар хамаг малаа алдаад байсан хөдөөгийн иргэдэд улс даяараа тусалж байсан юм. Хүйтэн, ширүүн салхинаас нүдээ хамгаалах гэж тэд шилэн терко нүдэндээ зүүсэн байсан” хэмээн гэрэл зурагчин Л.Ганзориг ярьсан юм.

<sup>19</sup> Гэрэл зурагчин Л. Санжмятав, Сүхбат нартай 2018 оны 4-р сарын 6-нд Туушин зочид буудлын 5-р давхрын 514 тоотод байрладаг Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны байранд ярилцав. Улаанбаатар хот.

1990-2000 оныг төлөөлөх гэрэл зурагчдаас товч дурдвал: “1977 онд гэрэл зураг авч Сэрээтэрийн Цацралт. 1982 онд ОХУ /Хуучнаар ЗХУ/-ын Эрхүү хотын Улсын Их Сургуулийг сэтгүүлч, гэрэл зурагчны мэргэжлээр төгссөн. “Залуучуудын үнэн”, “Үнэн”, “Ил товчоо” зэрэг сонинд гэрэл зурагчнаар ажиллаж, 1996 оноос гэрэл зургийн “Гамма” агентлагийг байгуулсан” (МГЗНХ, 2015: 182). Тэрээр баримтат гэрэл зураг, фото сэтгүүлзүйн төрлөөр дагнан ажилладаг. Тэрбишийн Өсөхбаатар гэрэл зургийн сэтгүүлч мэргэжилтэй. “1977 оноос эхлэн “Алтайн хөгжил”, “Анхдугаар таван жил”, “Пионерийн үнэн”, “Үнэн” сонинд анхны авсан зургуудаа нийтлүүлж байсан. “Ардын эрх” сонинд гэрэл зургийн сурвалжлагч, “Фотомон” агентлагийн захирлаар ажиллаж байсан. 1998, 2000 оны Шилдэг гэрэл зургийн сэтгүүлчийн шагналыг хүртэж байсан” (МГЗНХ, 2015: 194). 1982 оноос гэрэл зураг авч эхэлсэн гэрэл зургийн техникч, багш мэргэжилтэй Содномын Бадамханд. 1985-1995 онд Залуу техникчдийн ордонд багш “Пионерийн үнэн”, “Хүүхдийн хүмүүжил”, “Залуучуудын үнэн” зэрэг сонинд бүтээлээ нийтлүүлж байсан. Цэвэгмидийн Батзориг нь 1976 оноос гэрэл зураг авч эхэлсэн бөгөөд 1986-1992 онд ЗХУ-ын Ленинград хотын Улсын их сургуулийн сэтгүүлчийн ангийг фото сурвалжлагч мэргэжлээр төгссөн, сэтгүүлч, фото сэтгүүлч мэргэжилтэй. 1984-1986 онд МОНЦАМЭ агентлагийн дэргэдэх Улсын гэрэл зургийн газарт гэрэл зургийн лаборант, 1992-1996 онд МОНЦАМЭ агентлагт гэрэл зургийн сурвалжлагч, 1996 онд “ГАММА” агентлагийг С.Цацралт, Л.Ганзориг нартай хамтран байгуулсан. Вандандоржийн Баттулга нь 1986 оноос эхлэн гэрэл зураг авсан бөгөөд Москвад Кино Урлагийн дээд сургууль, “Магнум-Дорно дахинд” гэрэл зургийн сургалт, Монголын Хэвлэлийн Хүрээлэн, *Andrea Kunzig Lecturer International Institute for journalism InWEnt Berlin “News photography”* гэрэл зургийн сургалт, “Загварын гэрэл зураг” сургалт, “Гёте” институт, “Гамма” агентлагаас зохион байгуулсан “Соёл болон уур амьсгалын өөрчлөлт” гэрэл зургийн сургалтад тус тус суралцан төгсжээ. Лхагвасүрэн Элбэгзаяа нь 1971 онд төрсөн. 1989 оноос гэрэл зураг авч эхэлсэн. Тэрээр ихэвчлэн хүмүүс аж амьдрал, үйл явдал, нийгмийн сэдэвтэй гэрэл зураг авдаг гэрэл зурагчин, сэтгүүлч, фото шүүмжлэгч. Лхамсүрэн Ганзориг нь 1990 оноос гэрэл зураг авсан бөгөөд 1991-1992 онд “Монголын дуу хоолой” сонинд гэрэл зурагчин, 1996 оноос “ГАММА” агентлагийг үүсгэн байгуулалцаж, 2009 онд “*Kiin Images*” ХХК-ыг үүсгэн байгуулсан, 2015 онд Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн даргаар ажилласан. Цэрэндорж Батбаатар нь 1991 оноос гэрэл зураг авч эхэлсэн (МГЗНХ, 2015: 292).

**5. Ухаалаг утас, утасгүй холбоо, нийгмийн сүлжээ бий болсон үеэс одоо үе буюу 2000 оноос хойш:** Энэ үед гарсан хамгийн том ололт өөрчлөлт нь ухаалаг утас, утасгүй холбоо, нийгмийн сүлжээ юм. Гэхдээ эдгээрээс өмнө Монголд 2000 онд “*asuult.net*” хэмээх форум үйл ажиллагаагаа эхлүүлсэн байдаг. Энэ форумд хүмүүс хувийн орон зайгаа үүсгэж, бие биетэйгээ холбогдон уралдаан тэмцээн зохиох болсон билээ. Асуулт форумын зүгээс 2005 оноос гэрэл зураг сонирхогчдын дунд “Асуулт Фото Аялал” зохиох болсон нь гэрэл зурагчдын тоо нэмэгдэхэд томоохон хувь нэмэр оруулсан. Харин дэлхий нийтэд хувийн болон олон нийтэд зориулсан тэмдэглэл бичих зориулалттай блог (*blog*)-уудын хэрэглээ энэ үед оргил цэгтээ хүрч байсан ба гэрэл зураг болон видео бичлэг оруулах зориулалттай Фликр ([www.flickr.com](http://www.flickr.com)) 2004 оны 2 сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

2000 оноос Япон, дараа нь АНУ-д ухаалаг утас үйлдвэрлэх болж, 2002 онд утасгүй интернет холбогч хүлээн авагч (*router*), ухаалаг утсаа дагаад утасгүй интернет бий болсоноор *Instagram*, *Facebook* зэрэг гэрэл зураг, видео бичлэг хуваалцдаг нийгмийн сүлжээний үйлчилгээ гарч хэрэглэгчид нь өссөнөөр цахим ертөнцөд гэрэл зурагчид бүтээлүүдээ оруулж, бие биетэйгээ санал бодлоо хуваалцаж гэрэл зурагчдын тоо нэмэгдэхэд томоохон нөлөө үзүүлсэн. Энэ үеэс эхлээд хүн бүр гэрэл зурагчин болсон. Ийнхүү шинэ үеийнхний хэрэглээ, бүтээлээ дэлгэн үзүүлэх арга зам ч өөрчлөгдсөнөөр гэрэл зурагчид олон нийтэд танигдаж эхэлсэн. Энэ үеийн гол төлөөлөгчдөөс дурдвал, Базарсүхийн Рэнцэндорж, Борын Инжинааш, Дэлгэржаргалын Давааням, Ганхүүгийн Аргуужин, Х.Түшиг, Соёмбоо буюу Агнууш юм.

Утасгүй холбоо, нийгмийн сүлжээний эрэн үед гудамжны гэрэл зураг авах явдал хурдацтай нэмэгдсэн. Мөн хувь хүний эрх, зохиогчийн эрх, зургийг засварлах, манипуляцлах зэрэг сөрөг үр дагавар гарах нөхцөл бүрдсэн. Нийгэм, технологийн шинэ цаг үед наая гаруй түүхтэй гудамжны гэрэл зургийг төрлийг таниулах, гэрэл зурагчны ёс зүйг дэлгэрүүлэх, гэрэл зургийн үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд судлаачдын судлах шинэ орон зай билээ.

### Дүгнэлт

Монголд гэрэл зургийн алба хөгжсөнөөс хойш гудамжны гэрэл зураг зэрэгцэн хөгжсөн байна. Өнөө үед гэрэл зургийн төрлүүдээс гудамжны гэрэл зураг хүчтэй хөгжиж байгаа билээ. Уг судалгаагаараа бид дэлхийн болон Монголын гудамжны гэрэл зургийн хөгжил хийгээд гудамжны гэрэл зургийг тодорхойлсон байдлыг авч үзлээ. Ингэснээр гудамжны гэрэл зургийн хөгжлийг тодорхой харуулж, Монголын гудамжны гэрэл зургийг судалгааны эргэлтэд оруулж, гудамжны гэрэл зургийн үнэлэмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

### Ном зүй

**Edwards, Steven.** 2006. *Photography: A Very Short Introduction*. Oxford: Oxford University Press.

**Баттулга, Вандандорж.** 2015. *Ертөнцийг гэрлээр бичих урлаг*. Улаанбаатар.

Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбоо. 2015. *Монголын гэрэл зурагчид: Press 1935-2015*. Улаанбаатар.

**Норовсүрэн, Ломбо.** 2012. *Фото сэтгүүлзүй*. Улаанбаатар. Монгол улс

**Rosenblum, Noami.** 1981. *A World History of Photography*. New York: Abbeville Press.

**Sontag, Susan.** 1977. *On Photography*. New York: Penguin press.

**Warren, Lynne.** 2005. *Encyclopedia of 20th Century Photography. Volume I*. New York: Routledge

**Westerbeck, Colin., Meyerowitz, Joel.** 1992. *Bystander: A History of Street Photography*. New York: Laurence King Publishing;

Гэрэл зурагчин Л. Санжмятав, Сүхбат нартай 2018 оны 4-р сарын 6-нд Туушин зочид буудлын 5-р давхарын 514 тоотод байрладаг Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны байранд ярилцав. Улаанбаатар хот (хэвлэгдээгүй).

Талбайн гэрэл зурагчин Ц. Хэнзтэй 2017 оны 09-р сарын 20-нд 25-р телевизийн байрны нэгдүгээр давхарт ярилцав. Улаанбаатар хот (хэвлэгдээгүй).